



ДОРНОГОВЬ АЙМАГ
АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/48

Чулуунгишгэр

Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", Засгийн газрын 2025 оны 120 дугаар тогтоол, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын "Газар зохион байгуулалтын 2025 төлөвлөгөө"-нд тусгагдсан газарт газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Дуудлага худалдаагаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацаа, дуудлага худалдааны анхны үнэ, дэнчингийн хэмжээг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохих журмын дагуу цахимаар зохион байгуулахыг Алтанширээ сумын Газрын даамлын ажлыг түр орлон гүйцэтгэгч аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн /У.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /Н.Баярсайхан/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ГАН-ОД

4425020137

Сумын Засаг даргын 2025-оны 04 дүгээр сарын
29-ний өдрийн 44 дугаар захирамжийн хавсралт



ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ
АНХНЫ ҮНЭ, ДЭНЧИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Газрын байршил	Газрын зориулалт	Талбайн хэмжээ (га)	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Дуудлага худалдааны анхны үнэ (төг)	Дэнчингийн хэмжээ (төг)
1	3-р баг, Хаяа Цагаан хаалгааны орчимд	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	0.6	4217691	3 600 000 ₮	360 000
2	3-р баг, Хаяа Цагаан хаалгааны орчимд	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	3	4173005	18 000 000	1 800 000